


ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ

2023 оны 9 сар


МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

2023 оны 9 сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс **10.1%**-иар өсөж, өмнөх сараас **0.1%**-иар буурчээ. Хүнсний бүтээгдэхүүн, боловсролын үйлчилгээ, хувцас, бөс барааны үнийн өсөлт тус сарын инфляцыг өсөхөд голлон нөлөөлсөн байна. Нүүрсний экспортын хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад огцом өссөн нь урсгал тэнцэл эерэг гарахад түлхэц болов. Төлбөрийн тэнцэл сайжирснаар гадаад валютын албан нөөц 2023 оны 9 сарын эцсийн байдлаар **4.12 тэрбум долларт** хүрч, өмнөх оны мөн үеэс **48.0%**-иар нэмэгдэж, ханш тогтворжиход нөлөөлсөн байна.

Инфляц ба мөнгөний бодлогын хүү, (%)



Гадаад валютын нөөц, (тэрбум \$)




МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар


2023 онд Монгол Улс **50.00 сая тонн** нүүрс экспортолно гэж төлөвлөсөн бөгөөд 9 сарын байдлаар нүүрсний экспорт **48.92 сая тонн** хүрсэн нь өмнөх оны мөн үеэс **54.0%**-иар өссөн үзүүлэлт юм. 9 сард **экспорт** төсөөллөөс өндөр байсан мөн эдийн засгийн идэвх сайжирсантай холбоотой төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байжээ.

Төгрөгийн доллартой харьцах ханш өнгөрсөн оны 9 сарын эцэст оны эхнээс **494.75** төгрөгөөр суларсан байсан бол 2023 оны 9 сарын 30-ны байдлаар **3,460.47** төгрөгт хүрч, оны эхнээс **8.48** төгрөгөөр суларсан байна. Экспортоос олсон орлого нэмэгдэж, гадаад валютын цэвэр орох урсгал 2023 оны эхний 9 сарын турш эерэг байгаа нь ханш тогтвортой байх нөхцлийг бүрдүүлж байна.

Долларын ханш, (₮)




Эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ




МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 2 дахин өсөж 10.20 их наяд төгрөгт хүрсэн бол хувьцааны зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 1.9%-тай байна. 2023 оны 9 сарын 30-ны байдлаар нийт 635.29 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх сараас 7.0%-иар өссөн үзүүлэлт бөгөөд нийт арилжааны 73.0%-ийг хувьцаа, 11.0%-ийг компанийн бонд, 9.0%-ийг хөрөнгө оруулалтын сан, 7.0%-ийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар



Үнэт цаасны зах зээлийн арилжаа



МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

МХБ-ийн ТОП-20 индекс 9 сарын 30-ны байдлаар он гарснаас хойш -5.0%, MSE-B индекс -3.7%-иар унасан бол MSE-A индекс 7.2%-иар өссөн байна. Харин өмнөх сартай харьцуулахад ТОП-20 индекс өссөн бол MSE-A, MSE-B бууржээ. АНУ-ын ХНС инфляцтай тэмцэхийн тулд бодлогын хүүгээ өсгөж байгаа нь гадаад өрийн өртгийн нэмэгдүүлэх хандлагатай байна. Үүний үр дүнд монголын аж ахуйн нэгжүүдийн гадаад өрийн дарамтыг ихсэж, ашиг орлогод сөргөөр нөлөөлж байгаа юм. Ийнхүү компаниудын ашиг буурснаар үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг тул ТОП-20 индексэд уналт ажиглагдаж байна.


Индексүүдийн хөдөлгөөн , (оны эхнээс)




МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

ТОП-20 индекс дотроос Говь ХК-ийн ханш хамгийн их буюу 17%-иар өссөн ба тус өсөлт нь 8 сарын сүүлчээр Казакстан улсад охин компаниа нээсэнтэй холбоотой байж болох юм. Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн хувьцаа 8 сард 19.0%-иар унаж хамгийн их уналтыг үзүүлсэн бол 9 сард мөн 12.5%-иар унаж жагсаалтын сүүлд бичигджээ. Идэвхтэй арилжигддаг хувьцаанууд дунд уул уурхайн компаниудын хувьцаа үнэлгээгээрээ жин дардаг. Сүүлийн 1 жилийн хугацаанд Тавантолгой компанийн ханш хамгийн ихээр буюу 40.1%-иар өссөн бөгөөд энэхүү өсөлтийг энэ жилийн Монгол улсын эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болно.

1 сарын өөрчлөлт, (%)




1 жилийн өөрчлөлт, (%)



МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

2023 оны 1 сараас 9 сарын 30-ны хооронд 16 компанийн хувьцаа дээр **63** удаагийн багцын арилжаа явагдаж, нийт **51.6 тэрбум** төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Хамгийн сүүлд 9 сарын 27-нд **Богд Банк ХК**-ийн хувьцаа нь дээр **297 сая** төгрөгийн арилжаа явагдсан бөгөөд нэгж хувьцаа нь **95** төгрөгөөр арилжаалагджээ. 9 сарын 21-нд **АПУ ХК** дээр тухайн сарын хамгийн өндөр үнэтэй буюу **906 сая** төгрөгийн багцын арилжаа хийгдсэн байна. Он гарснаас хойш **Инвескор ББСБ ХК**-ийн хувьцаан дээр ний **17** удаагийн **15.6 тэрбум** төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжааны явагдсанаар жагсаалтыг тэргүүлж байгаа бол удаах байруудад Худалдаа Хөгжлийн банк ХК, АПУ ХК, Голомт Банк ХК нар орж байна.

МХБ-ийн 9 сарын хувьцааны багцын арилжаа (тэрбум ₮)



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

АНУ-ын инфляц цаашид буурч эдийн засгийн өсөлт буурсан тохиолдолд бодлогын хүүгийн түвшин буурч, жилийн төгсгөлд хөрөнгийн зах зээл дахин сэргэх нөхцөл байдал бүрдэх боломжтой болох юм. 9 сард АНУ ЗГҮЦ-ны өгөөжийг нэмэгдүүлсэн нь хөрөнгийн зах зээлийг жолоодсон гол хөдөлгүүр болсон бөгөөд 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж өнгөрсөн 9 сарын сүүлийн 7 хоногт хормын зуур 4.6% болж 2007 оноос хойш хамгийн дээд цэгтээ хүрсэн юм. Сүүлийн жил хагасын хугацаанд бодлогын хүүгийн гэнэтийн өсөлт хөрөнгийн зах зээлийг өсгөдөг хандлага ажиглагдсан. Доорх хүснэгтээс харахад, хүү өссөн дээрх дөрвөн тохиолдол бүрд S&P 500 буурч байсан бол дараагийн саруудаас өгөөж эерэг болсон байна.

АНУ-ын инфляц, (%)



Хүүгийн өсөлтийн үеэр мөн дараах S&P 500-ын ханшийн өөрчлөлт


Хүүгийн түвшин өссөн үе	10 жилийн ЗГҮЦ-ны өгөөж	Тухайн үеийн хөрөнгийн зах зээлийн өгөөж	Нэг сарын дараах хөрөнгийн зах зээлийн өгөөж	Гурван сарын дараах хөрөнгийн зах зээлийн өгөөж
3/11/22-6/14/22	+1.8%	-13.3%	+1.6%	+6.1%
8/1/22-10/24/22	+1.7%	-6.8%	+6.3%	+6.3%
2/1/23-3/2/23	+0.7%	-3.2%	+3.7%	+8.0%
8/31/23-9/29/23	+0.4%	-4.6%	?	?

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

Түүхэн хугацаанд бодлогын хүүгийн өсөлт хөрөнгийн зах зээлийн өгөөжид сөргөөр нөлөөлсөн хэдий ч 10 жилийн ЗГҮЦ-ны өндөр өгөөж хөрөнгийн зах зээлийн өсөлтөд түлхэц болсоор ирсэн. Цаашид ХНС одоогийнхоос илүү хатуу мөнгөний бодлого руу шилжих магадлал тун бага байна. Учир нь инфляцыг зорилтод түвшин хүртэл бууруулахын тулд дахиж бодлогын хүүг өсгөх шаардлага байхгүй байна. Гэсэн хэдий ч бодлогын хүүг өсгөсөн тохиолдолд хувьцааны ханш буурч хөрөнгө оруулагчдад илүү ашигтай нөхцөл байдал үүсэх боломжтой юм.

Доорх зурагт сүүлийн үеийн хүүгийн өсөлтийн үеэрх **S&P 500**-ийн ханшийг тусгав. Өгөөж дээд цэгтээ хүрсний дараа **S&P 500** өсөж байв.


Бодлогын хүү ба хөрөнгийн зах зээл



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ – 2023 оны 9 сар

Түүхэн үзүүлэлтээс харахад сулхан гүйцэтгэлтэй байсан III улирал ихэвчлэн хүчтэй төгсгөл араасаа дагуулдаг бөгөөд ирэх саруудад зах зээлийн нөхцөл байдал одоогоос сайжрах төлөвтэй байна. 1990 оноос хойш 11 жилийн 9-д нь III улиралд S&P 500 индекс унаж байсан бол IV улирлаас ойролцоогоор 10.6% өсөлт үзүүлсэн байна. Доорх зурагт 1990-2022 оны IV улирлын гүйцэтгэлийг тусгасан бөгөөд улирлыг өгөөж ойролцоогоор 5.0% байв. Үүнээс харахад жилийн төгсгөлийг хөрөнгийн зах зээлийн хувьд тогтвортой үе гэж хэлж болохоор байна.

IV улирлын хувьцааны гүйцэтгэл



Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөлтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

Бэлтгэсэн: Д. Гантуяа.
Хөрөнгө оруулалтын шинжээч

Утас: 9963 1005
И-мэйл: gantuya.d@ardsecurities.com